



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 11 дугаар сарын 21

№ 01/90

Мандалговь хот

Г Зөрчил арилгуулах тухай Т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрх, Монгол улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн аудитын журмын 1.9-дэхь заалт, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дэлгэрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

1. Багши нарын сургалтын арга зүй, цагийн тооцоонд хяналт тавих албан тушаалтан буюу сургалтын менежер 737,795.00 /Долоон зуун гучин долоон мянга долоон зуун ерэн тае/ төгрөгийн анги даалтын нэмэгдэл болон илүү цагийн хөлс авсан.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 28.1-д /Хуулийн этгээдэд эд хөрөнгө захиран зарцуулах эрх мэдэл хэрэгжүүлэх ажил, албан тушаалд ажилладаа ажилтан адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бусад төрөл, хэлбэрийн өмчлөгчийн эрхэлжээ байгаа ажил, албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжстэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцээн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно. Мөн хуулийн 28.2./Энэ хуулийн 28.1 нь хавсрал ажиллахад нэгэн адил хамаарна-д заасныг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэгээрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитёр, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Сургалтын арга зүй, цагийн тооцоонд хяналт тавих албан тушаалтнаар ажил орлон гүйцэтгүүлж илүү цаг олгохгүй байх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх;

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 12 сарын 15-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дэлгэрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ж.Өлзийжаргал, нягтлан бодогч Т.Дулмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ


ӨГСӨН¹:



СУРГУУЛИЙН ЗАХИРАД

ЗӨВШӨӨРСӨН:

НЯГТЛАН БОДОГЧ



¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зорчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна/